

МӨНГӨНИЙ ТОЙМ

2017 оны 9 дүгээр сар

- Мөнгөний нийлүүлэлт 2017 оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 27.6%-иар, өмнөх сараас 1.5%-иар тус тус өсч 14.8 их наяд төгрөг болов.
- Мөнгөний нийлүүлэлтийн сарын өсөлтийг валютын хадгаламжийн өсөлт тодорхойлж байна.
- Нөөц мөнгө өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй буюу 3.3 их наяд төгрөг байна.
- Нийт хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл тайлант сард 156.5 тэрбум төгрөгөөр өсч, 13.4 их наяд төгрөгт хүрэв. Үүний 50 хувь нь хувийн хэвшилд, 49.3 хувь нь иргэдэд олгосон зээл байна.
- Хадгаламжийн байгууллагуудын нийт зээлийн 6.2 хувь нь хугацаа хэтэрсэн, 8.7 хувь нь чанаргүй зээл байна. Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх сараас 0.9 нэгж хувиар, чанаргүй зээлийнх 0.1 нэгж хувиар тус тус буурчээ.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

		2016		2017			
		12-р сар	3-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар
Инфляци							
Улаанбаатар хотын	сарын	0.7	1.6	-0.6	-0.1	1.3	0.5
	оны эхнээс	0.5	3.2	4.8	4.7	6.0	6.6
	жилийн	0.5	3.0	3.5	3.3	5.4	6.6
Суурь	сарын	0.3	0.7	0.1	0.0	1.4	0.8
	оны эхнээс	0.5	0.9	2.7	2.7	4.2	5.0
	жилийн	0.5	2.8	4.7	4.0	5.1	5.9
Улсын	сарын	0.6	1.2	-0.6	0.1	0.8	0.2
	оны эхнээс	1.1	3.0	4.1	4.2	5.1	5.3
	жилийн	1.1	3.1	3.3	3.4	5.0	5.8
Мөнгө, санхүүгийн сектор							
Нөөц мөнгө, тэрбум ₮		3,064.4	2,749.9	3,179.5	3,000.6	3,299.2	3,269.8
сарын өөрчлөлт, хувиар		-5.7	2.8	6.5	-5.6	10.0	-0.9
жилийн өөрчлөлт, хувиар		24.6	17.0	-9.8	-7.1	1.3	5.6
M2 мөнгө, тэрбум ₮		12,158.6	12,260.2	13,484.1	13,999.6	14,526.3	14,749.7
сарын өөрчлөлт, хувиар		3.7	-0.6	3.8	3.8	3.8	1.5
жилийн өөрчлөлт, хувиар		21.0	21.2	20.5	23.8	27.7	27.6
Бусад хадгаламж, тэрбум ₮		10,010.8	10,134.4	10,763.5	11,415.4	11,767.3	11,949.3
сарын өөрчлөлт, хувиар		2.2	-0.2	2.5	6.1	3.1	1.5
жилийн өөрчлөлт, хувиар		19.7	18.8	16.9	21.9	25.3	25.3
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум ₮		823.6	788.3	915.0	887.6	899.6	878.9
сарын өөрчлөлт, хувиар		7.1	-16.6	4.5	-3.0	1.4	-2.3
жилийн өөрчлөлт, хувиар		16.6	19.7	9.0	8.5	10.1	10.4
Хад.байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮		12,422.7	12,678.5	12,903.1	13,038.4	13,265.0	13,421.4
сарын өөрчлөлт, хувиар		-2.3	0.8	1.5	1.0	1.7	1.2
жилийн өөрчлөлт, хувиар		6.1	7.1	7.3	7.7	6.6	7.4
Хад.байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, тэрбум ₮		1,051.7	1,035.5	1,132.3	1,149.7	1,171.2	1,169.5
сарын өөрчлөлт, хувиар		-9.9	-3.2	-2.2	1.5	1.9	-0.1
жилийн өөрчлөлт, хувиар		20.9	7.0	9.3	11.7	4.0	4.5
Мөнгөний үржүүлэгч		4.0	4.5	4.2	4.7	4.4	4.5
Банк хоорондын зах							
Илүүдэл нөөц, сая төгрөгөөр		-24.0	-58.7	-73.5	-78.9	-44.4	-56.1
сарын өөрчлөлт, хувиар		50.3	-60.9	-127.5	-7.3	43.7	-26.4
Илүүдэл нөөц - Байнгын санхүүжилт		-5,955.0	-24,819.1	-28,842.1	10,733.1	-1,845.7	-45,500.1
сарын өөрчлөлт, хувиар		81.4	-526.2	-963.0	137.2	117.2	-2,365.2
Илүүдэл нөөц - ТБ-ны буцах санхүүжилт + ОН + ТБҮЦ		530,470.2	895,349.6	1,604,933.3	1,592,329.7	1,622,833.6	1,931,172.7
сарын өөрчлөлт, хувиар		-40.0	75.5	24.5	-0.8	1.9	19.0
Хүү (хувиар)							
Хадгаламжийн ЖДХ		13.1	13.0	12.1	12.8	12.5	13.0
Хадгаламжийн бодит хүү*		12.6	10.0	8.6	9.4	7.1	6.3
Зээлийн ЖДХ**		19.7	20.2	20.3	20.1	20.1	19.9
Зээлийн бодит хүү*		19.2	17.2	16.8	16.7	14.7	13.2
Ипотекийн зээлийн хүү		10.3	10.3	10.2	10.1	10.1	10.1
ТБҮЦ-ны ЖДХ		14.5	14.0	12.9	12.0	12.0	12.0
Бодлогын хүү		14.0	14.0	12.0	12.0	12.0	12.0
БХЗ-ын ЖДХ		15.5	15.0	13.1	12.3	12.2	12.1

* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

** Тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

М2 мөнгөний нийлүүлэлтийн 51.4%-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 16.6%-ийг валютын хадгаламж, 14.6%-ийг төгрөгийн харилцах, 12.9%-ийг валютын харилцах, үлдсэн хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.

М2 мөнгө өмнөх оны мөн үеэс 27.6 хувиар өссөн нь өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Жилийн өсөлтийн дийлэнх хувийг төгрөгийн хадгаламж бүрдүүлсэн хэвээр байгаа ба өсөлтөд эзлэх хувь хэмжээ өмнөх сараас 1.5 нэгж хувиар буурсан байна. Түүнчлэн валютын харилцахын мөнгөний өсөлтөнд үзүүлэх хувь хэмжээ өмнөх сараас 1 нэгж хувиар буурсан бол валютын хадгаламжийнх 2.5 нэгж хувиар өсөв.

Өмнөх сараас М2 мөнгөний нийлүүлэлт 1.5% (223.8 тэрбум төгрөгөөр)-иар өсч 14.8 их наяд төгрөгт хүрэв. Үүнд М1 мөнгө 1.5% (41.8 тэрбум)-иар, бусад хадгаламж 1.5% (182.1 тэрбум)-иар тус тус өсөв.

Бусад хадгаламжийн бүрэлдэхүүн хэсгүүдээс валютын хадгаламж 186.7 тэрбум төгрөгөөр, валютын харилцах 39.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол төгрөгийн хадгаламж 43.8 тэрбум төгрөгөөр буурчээ.

М1 мөнгөний бүрэлдэхүүн хэсгээс төгрөгийн харилцах 60.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байхад хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 18.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 1. М2 жилийн өсөлтийн задаргаа (эх үүсвэрээр)



Зураг 2. М2 сарын өсөлтийн задаргаа (эх үүсвэрээр)




Зураг 3. М2 сарын өөрчлөлт, тэрбум ₮



Нийт хадгаламжийн 83.7%-ийг иргэдийн хадгаламж бүрдүүлж байна. Харин гадаад валютын хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 25.9%-д хүрч өмнөх сараас 1.5 нэгж хувиар өсчээ.

Тайлант сард иргэдийн гадаад валютын хадгаламж өмнөх сараас 7.8%-иар, байгууллагын валютын хадгаламж 7.3%-иар, нийт дүнгээр 6.6%-иар нэмэгдсэн байна.

Зураг 4. Хадгаламжийн үлдэгдэл (иргэд, байгууллага)



Гадаад, дотоод актив

М2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 118.5 тэрбум төгрөгөөр, дотоод цэвэр актив 104.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Гадаад цэвэр активын өөрчлөлтөд Төв банкны гадаад цэвэр актив 80.8 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Дотоод активаас Засгийн газраас авах цэвэр авлага 56.3 тэрбум төгрөгөөр, иргэдээс авах авлага 171.1 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.


Тайлант сард нөөц мөнгө 3.3 их наяд төгрөг байгаа нь өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Нөөц мөнгөний 73.2 хувийг банкуудын харилцах, 18.9 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 7.9 хувийг банкуудын касс дахь мөнгө бүрдүүлж байна.

Зураг 5. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



Зураг 6. Нөөц мөнгө



Хадгаламжийн байгууллагын зээлийн үлдэгдэл


Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 156.5 тэрбум төгрөгөөр өсч 13.4 их наяд төгрөг болжээ.

Нийт зээлийн үлдэгдлийн 50 хувийг хувийн хэвшилд, 49.3 хувийг иргэдэд, 0.8 хувийг бусад салбарт олгосон зээл бүрдүүлж байна.


Нийт зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.9 нэгж хувиар буурч 6.2 хувьд, чанаргүй зээлийн хувь 0.1 нэгж хувиар буурч 8.7 хувьд тус тус хүрчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн 81.6 хувийг, чанаргүй зээлийн 79.4 хувийг хувийн хэвшилд олгосон зээл эзэлж байна.

Зураг 7. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 8. Хадгаламжийн байгууллагын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл




Мөнгөний зах

Тухайн сард банк хоорондын мөнгөний захаар дамжуулан банкууд 702.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 37.4 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа, 28.7 хувийг овернайт зээл, 19.1 хувийг ЗГҮЦ-ны арилжаа, 1.6 хувийг банк хоорондын хадгаламж, 13.2 хувийг репо арилжаа тус тус бүрдүүлжээ.

Банкууд заавал байлгах нөөцийн шаардлагыг хангах, тооцоо, гүйлгээний зорилгоор 2017 оны 8 дугаар сарын 30-ны өдрөөс 9 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд 1247.6 тэрбум, 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд 1338.9 тэрбум төгрөгийг Монголбанк дахь төгрөгийн харилцахад, дээрх хугацаанд харгалзан 581.6 тэрбум болон 588.9 тэрбум төгрөгтэй тэнцэх валютыг валютын харилцах дансанд тус тус байршуулжээ.

Зураг 9. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү




Хүү

Тайлант сард төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн хүү 0.2 нэгж хувиар буурч 19.9%, үлдэгдэлд жигнэсэн хүү 0.2 нэгж хувиар өсч 18.4%-д тус тус хүрчээ. Харин эдгээрийг жилийн өмнөх түвшинтэй харьцуулахад олгосон зээлийн хүү мөн 0.2 нэгж хувиар буурсан байхад үлдэгдлээр жигнэсэн хүү өөрчлөгдөөгүй байна.


Валютын зээлийн хувьд тухайн сард олгосон зээлийн хүү 11.6%, зээлийн үлдэгдлээр жигнэсэн хүү 11.4% байгаа нь өмнөх сарынхаас тус бүр 0.1 нэгж хувиар буурсан үзүүлэлт байна. Жилийн өмнөхөөс олгосон зээлийн хувьд 0.9 нэгж хувиар, үлдэгдлийн хувьд 0.2 нэгж хувиар тус тус буурсан байна.

Төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээр жигнэсэн хүү өмнөх сараас 0.4 нэгж хувиар өсч 13%, тухайн сард татсан хадгаламжийн жигнэсэн хүү 0.1 нэгж хувиар өсч 12.4%-д тус тус хүрчээ. Гадаад валютын хадгаламжийн хувьд үлдэгдлээр жигнэсэн хүү өмнөх сараас 0.3 нэгж хувиар өсч 5.7%, шинээр татсан хадгаламжийн хүү 0.1 нэгж хувиар буурч 5.1% болжээ.

Зураг 10. Зээлийн жигнэсэн дундаж хүү



Зураг 11. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү




Валютын ханш

2017 оны 9 дүгээр сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1.4 хувь буюу 34.38 төгрөгөөр суларч 2464.43 төгрөгт хүрчээ. Тухайн сарын дундаж ханш 10.76 төгрөгөөр суларч 2454.29 төгрөг байв. 2017 оны 9 дүгээр сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 17.34 төгрөгөөр суларч 2906.67, БНХАУ-ын юаньтай харьцах ханш 2.29 төгрөгөөр суларч 370.72, ОХУ-ын рубльтай харьцах ханш 1.02 төгрөгөөр суларч 42.52-д тус тус хүрэв.

Тайлант сард төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 1.8%-иар буурсан буюу төгрөгийн гадаад валюттай харьцах ханш энэ хэмжээгээр сулав.


Зураг 12. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100



Инфляци

Зураг 13. Улаанбаатар хотын сарын инфляци

2017 оны 9 дүгээр сард инфляци УБ хотын хэмжээнд өмнөх сараас 0.5 хувиар өссөн байна. Үүнд хүнснээс бусад барааны үнийн өсөлт нөлөө үзүүлсэн байна. Тодруулбал, сарын өсөлтийн 0.7 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнэ, -0.2 нэгж хувийг хүнсний барааны үнэ бүрдүүлжээ. Хүнснээс бусад барааны өсөлтөд түлшний мод, нүүрс, гутал, суудлын автомашины үнийн өсөлт гол нөлөө үзүүлсэн байна. Харин хүнсний бүлгийн үнэ буурахад махны үнийн бууралт гол нөлөө үзүүлэв.



Жилийн инфляци УБ хотын хэмжээнд тайлант сард 6.6 хувь байгаагийн 4.4 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээ, 2.2 нэгж хувийг хүнсний бараа, бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна.

Хүнсний бүлгийн үнэ жилийн 9.2 хувийн өсөлттэй байгаагаас хүнсний ногооны үнэ 35.5 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 13.1 хувиар, мах, махан бүтээгдэхүүний үнэ 5.4 хувиар өсчээ. Харин хүнснээс бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ жилийн 5.8 хувийн өсөлттэй байгаагаас тээвэр 10.4 хувиар, орон сууц, ус, цахилгааны үнэ 10.9 хувиар, боловсролын бүлгийн үнэ 7.4 хувиар өсчээ.

Зураг 14. Улаанбаатар хотын жилийн инфляци

